



ТӨВ АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
XIV ХУРАЛДААНЫ ТОГТООЛ

2023 оны 02 сарын 01 өдөр

Дугаар 02

Зуунмод

“Аймгийн Засаг даргын 2020-2024 оны
үйл ажиллагааны хөтөлбөр”-ийн хэрэгжилтийн
явцыг дүгнэх тухай


Аймгийн Засаг дарга Д.Мөнхбаатарын өргөн мэдүүлсэн “Аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-ийн хэрэгжилтийн явцын тайлан, мэдээлэл, түүнд Хурлын Хороодоос хийсэн дүгнэлт, Хурлын Төлөөлөгчдөөс гарсан саналыг ХЭЛЭЛЦЭЭД:

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.5, 48 дугаар зүйлийн 48.1 дэх заалтыг тус тус үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас ТОГТООХ нь:

1. “Аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-ийн хэрэгжилтийн явц 91.81 хувийн гүйцэтгэлтэй тул “Тодорхой үр дүнд хүрсэн” гэж дүгнэсүгэй.

2. Тус хөтөлбөрөөс хэрэгжилт удаашралтай ажил, арга хэмжээнүүдийг эрчимжүүлэх, шаардлагатай төсөв хөрөнгийг шийдвэрлэн, хэрэгжилтийг бүрэн хангаж, гүйцэтгэл, үр дүнг тайлагнаж ажиллахыг аймгийн Засаг дарга /Д.Мөнхбаатар/- д даалгасугай.

3. Энэхүү бодлогын баримт бичгийн хэрэгжилтэд хийх хяналт-шинжилгээг хорооны төлөвлөгөөнд тусган батлуулж, тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Хороодод үүрэг болгосугай.

ДАРГА () Ц.ЖАМБАЛСҮРЭН

413010001

Togtool-ITH-2023

**АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН 2020-2024 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ
ХӨТӨЛБӨРИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ТОВЧОО**

2023.01.24

Зуунмод

№	Бүлэг	Зорилт	Арга хэмжээ	Үр дүнтэй 100%	Тодорхой үр дүнд хүрсэн 70-100%	Эрчимжүүлэх шаардлагатай 30-70%	Үр дүнгүй 0-30%	Дундаж үнэлгээ
1	“Ковид – 19” цар тахлаас үүдэлтэй эдийн засаг, нийгмийн хүндрэлийг даван туулах бодлого	3	8	7	1	-	-	98.75%
2	Хүний хөгжлийн бодлого	18	67	50	12	3	2	92.15%
3	Эдийн засгийн бодлого	2	13	13	-	-	-	100%
4	Хөдөө аж ахуй, үйлдвэрлэлийн бодлого	3	37	26	9	2	-	92.89%
5	Ногоон хөгжлийн бодлого	5	39	29	7	1	2	91.44%
6	Бүс, орон нутгийн хөгжлийн бодлого	9	56	32	12	8	4	84.08%
7	Засаглалын бодлого	11	51	40	10	-	1	95.16%
8	Аймаг, сум, нийгэм, эдийн засгийн салбар үүсч байгуулагдсаны түүхт ой угтсан бүтээлч ажил	1	3	1	2	-	-	80.0%
	Дүн	52	274	198	53	14	9	91.81%

ТАНИЛЦАЖ ЗӨВШӨӨРСӨН:
АЙМГИЙН ЗАСАГ ДАРГА **Д.МОНХБААТАР**

ХЯНАСАН:
ТӨРИЙН ЗАХИРГААНЫ ХУРАЛ АХУЙН ХЭЛТСИЙН ДАРГА **С.МАГНАЙБАЯР**

НЭГТГЭСЭН:
ТӨРИЙН ЗАХИРГААНЫ УДИРДЛАГЫН ХЭЛТСИЙН АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН **Б.ОЮУНЦЭЦЭГ**

600